



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Завхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2026/036/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаангом хот 2026 он	Увс аймаг дахь Төрийн аудитын газар, Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn Аудитын менежер: М.Бат-Амгалан Утас: 70453317, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Авирмэд Утас: 70453317, Цахим хаяг: AvirmedB@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **Агуулга**

### **1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ**

### **2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

- 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан
- 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
- 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
- 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан
- 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
- 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

- 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
- 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
- 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд
- 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв
  - 3.5.1 Төсвийн төлөвлөлт
  - 3.5.2 Төсвийн гүйцэтгэл
  - 3.5.3 Нэмэлт төсөв

### **4. АУДИТЫН ТАЙЛАН**

- 4.1 Ерөнхий зүйл
- 4.2 Материаллаг байдал
- 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
  - 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт
  - 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
  - 4.5.1 Завсрын аудитын талаар
  - 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

### **6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

#### **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**УВС АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,  
Ө.Бадрахын гудамж  
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,  
E-mail: uvs@audit.gov.mn

ЗАВХАН СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ М.ЭНХТУЯА ТАНАА

2026.02.24 № УВА-2026/036/НА-СНА-ТШЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Завхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Завхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Завхан сумын Ерөнхий боловсролын сургууль нь захирлын 2025 оны Б/47, Б/53 дугаар тушаалуудаар батлагдсан бүтэц, орон тоонд байхгүй статистик үнэлгээ хариуцсан сургалтын менежер, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан гэсэн 2 орон тоог хавсруулан гүйцэтгүүлж 4,910.8 мянган төгрөгийн нэмэгдэл олгосон нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтад "Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулна", 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалтад "Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэгт "Төрийн албан хаагч хуульд зааснаас гадна дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно", 39.1.2 дахь заалтад "албаны эрх мэдлээ хэтрүүлэх", Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан зардлын эдийн засгийн ангиллыг зөрчиж 2,658.3 мянган төгрөгийн 11 гүйлгээ, анхан шатны бүрдэл дутуу баримтаар 3,418.0 мянган төгрөгийн 4 гүйлгээ, хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан

шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтад “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй, Нийцсэн бөгөөд Зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **Асуудлыг онцолсон хэсэг**

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

### **Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

### **Бусад асуудлын хэсэг**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>206627707.43</u></b>	<b><u>191802433.24</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	99,663,154.74	75,883,088.63
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	99,663,154.74	75,883,088.63
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	99,663,154.74	75,883,088.63
31211	Төрийн сангийн харилцах	99,663,154.74	75,883,088.63
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	00.00	691,263.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	691,263.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	106,964,552.69	115,228,081.61
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	632,000.00	632,000.00
35130	Эм боох материал	632,000.00	632,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	106,332,552.69	114,596,081.61
35410	Бичиг хэргийн материал	27,914,409.87	29,789,759.09
35420	Аж ахуйн материал	24,026,800.00	25,992,800.00
35460	Хүнсний материал	5,624,605.00	6,092,284.70
35470	Бусад хангамжийн материал	48,766,737.82	52,721,237.82
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>2,339,763,603.14</u></b>	<b><u>2,221,062,899.93</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	2,339,763,603.14	2,221,062,899.93
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	2,282,014,936.74	2,164,080,899.93
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,341,833,643.00	2,341,833,643.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-348,054,715.84	-454,462,247.52
39203	Авто-тээврийн хэрэгсэл	00.00	20,000,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	277,942,406.29	296,806,306.29
39206	Хуримтлагдсан элэгдэл	-150,969,696.70	-196,611,158.52
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	150,619,059.65	162,619,059.65
39208	Хуримтлагдсан элэгдэл	-86,773,224.30	-98,149,679.09
39214	Бусад үндсэн хөрөнгө	98,647,659.00	101,147,659.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-22,754,686.72	-30,627,175.24
39217	Ном	21,524,492.36	21,524,492.36
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	57,748,666.40	56,982,000.00
39301	Програм хангамж	2,300,000.00	2,300,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,533,333.60	-2,300,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	56,982,000.00	56,982,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>2,546,391,310.57</u></b>	<b><u>2,412,865,333.17</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>7,496,717.00</u></b>	<b><u>2,129,280.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	7,496,717.00	2,129,280.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	7,496,717.00	2,129,280.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	7,496,717.00	2,129,280.00
41361	Байгууллагад төлөх өглөг	7,496,717.00	2,129,280.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>2,538,894,593.57</u></b>	<b><u>2,410,736,053.17</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	2,538,894,593.57	2,410,736,053.17

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	523,127,158.64	523,127,158.64
51101	Өмч: - төрийн	523,127,158.64	523,127,158.64
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>987,046,716.56</b>	<b>858,888,176.16</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	987,046,716.56	987,046,716.56
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-128,158,540.40
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,028,720,718.37	1,028,720,718.37
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>2,546,391,310.57</u></b>	<b><u>2,412,865,333.17</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,032,836,835.67</b>	<b>1,814,160,249.22</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>546,113,135.67</b>	<b>50,392,749.22</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>546,113,135.67</b>	<b>50,392,749.22</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	546,113,135.67	50,392,749.22
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,640,100.00	2,368,400.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	1,140,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	543,473,035.67	46,884,349.22
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,486,723,700.00</b>	<b>1,763,767,500.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,330,583,100.00</b>	<b>1,625,850,900.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,330,583,100.00	1,625,850,900.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>00.00</b>	<b>137,000.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	137,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>156,140,600.00</b>	<b>137,779,600.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	156,140,600.00	137,779,600.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,503,936,350.94</b>	<b>1,942,318,789.62</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,503,936,350.94</b>	<b>1,942,318,789.62</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,461,850,200.82</b>	<b>1,882,643,109.62</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,004,085,712.00</b>	<b>1,287,397,994.00</b>
210101	Үндсэн цалин	643,104,198.00	759,248,104.00
210102	Нэмэгдэл	323,291,104.00	448,542,581.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	37,002,104.00
210104	Урамшуулал	37,690,410.00	42,605,205.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>126,192,883.33</b>	<b>161,947,527.68</b>
210201	Тэтгэврийн даатгал	85,810,208.46	109,872,763.25
210202	Тэтгэмжийн даатгал	10,041,564.05	12,938,769.13
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,309,057.04	7,108,160.94
210204	Ажилгүйдлийн даатгал	5,080,379.67	6,391,425.16
210205	Эрүүл мэндийн даатгал	19,951,674.11	25,636,409.20

<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	151,717,719.88	133,976,600.00
210301	Гэрэл, цахилгаан	7,089,419.88	13,712,250.00
210302	Түлш, халаалт	143,144,800.00	120,264,350.00
210303	Цэвэр, бохир ус	1,483,500.00	00.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	17,894,150.00	18,378,010.00
210401	Бичиг хэрэг	2,076,650.00	1,121,500.00
210402	Тээвэр, шатахуун	11,564,750.00	11,364,110.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,252,750.00	5,892,400.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	33,376,360.60	65,889,152.40
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	720,600.00	435,000.00
210502	Хоол, хүнс	32,655,760.60	65,454,152.40
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	3,709,300.00	3,696,500.00
210604	Урсгал засвар	3,709,300.00	3,696,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	150,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	150,000.00	00.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	18,563,516.33	20,919,732.33
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,430,300.00	2,391,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	13,133,216.33	18,528,232.33
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	106,160,558.68	190,437,593.21
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,842,500.00	10,522,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,224,250.00	7,850,390.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	98,093,808.68	172,064,603.21
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	42,086,150.12	59,675,680.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	40,302,370.00	59,675,680.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	40,302,370.00	59,675,680.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	1,783,780.12	00.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>528,900,484.73</u></b>	<b><u>-128,158,540.40</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>528,900,484.73</u></b>	<b><u>-128,158,540.40</u></b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>1,489,363,800.00</u></b>	<b><u>1,767,275,900.00</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,640,100.00</b>	<b>3,508,400.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	2,640,100.00	3,508,400.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	2,640,100.00	3,508,400.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,640,100.00	2,368,400.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	1,140,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,486,723,700.00</b>	<b>1,763,767,500.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,330,583,100.00	1,625,850,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,330,583,100.00	1,625,850,900.00

1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	137,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	137,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	156,140,600.00	137,779,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	156,140,600.00	137,779,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<b>1,437,645,556.16</b>	<b>1,791,055,966.11</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<b>1,437,645,556.16</b>	<b>1,791,055,966.11</b>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<b>1,397,649,486.04</b>	<b>1,731,267,266.11</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,004,085,712.00	1,288,089,257.00
210101	Үндсэн цалин	643,104,198.00	750,432,967.00
210102	Нэмэгдэл	323,291,104.00	458,048,981.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	37,002,104.00
210104	Урамшуулал	37,690,410.00	42,605,205.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	126,192,883.33	161,947,527.68
210201	Тэтгэврийн даатгал	85,810,208.46	109,872,763.25
210202	Тэтгэмжийн даатгал	10,041,564.05	12,938,769.13
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,309,057.04	7,108,160.94
210204	Ажилгүйдлийн даатгал	5,080,379.67	6,391,425.16
210205	Эрүүл мэндийн даатгал	19,951,674.11	25,636,409.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	151,364,019.88	135,079,600.00
210301	Гэрэл, цахилгаан	7,089,419.88	12,559,250.00
210302	Түлш, халаалт	143,144,800.00	120,264,350.00
210303	Цэвэр, бохир ус	1,129,800.00	2,256,000.00
2105	Нормативт зардал	30,993,371.50	64,819,532.10
210502	Хоол, хүнс	30,993,371.50	64,819,532.10
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,992,800.00	2,700,000.00
210604	Урсгал засвар	2,992,800.00	2,700,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,153,899.33	20,938,539.33
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,640,100.00	2,368,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	22,513,799.33	18,570,139.33
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	56,866,800.00	57,692,810.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	46,911,700.00	50,921,710.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,955,100.00	6,771,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	<b>39,996,070.12</b>	<b>59,788,700.00</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	38,212,290.00	59,788,700.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	38,212,290.00	59,788,700.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,783,780.12	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<b>51,718,243.84</b>	<b>-23,780,066.11</b>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	51,718,243.84	-23,780,066.11
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	47,944,910.90	99,663,154.74

10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	99,663,154.74	75,883,088.63
----	---	---------------	---------------

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл</b>	479,487,158.64	386,771,104.00	-88,146,469.89	778,111,792.75
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	317,128.00	317,128.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>479,487,158.64</b>	<b>386,771,104.00</b>	<b>-87,829,341.89</b>	<b>778,428,920.75</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	-317,128.00	00.00	-317,128.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	58,880,161.24	58,880,161.24
<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>523,127,158.64</b>	<b>1,028,720,718.37</b>	<b>987,046,716.56</b>	<b>2,538,894,593.57</b>
<b>2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл</b>	<b>523,127,158.64</b>	<b>1,028,720,718.37</b>	<b>987,046,716.56</b>	<b>2,538,894,593.57</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>523,127,158.64</b>	<b>1,028,720,718.37</b>	<b>987,046,716.56</b>	<b>2,538,894,593.57</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-128,158,540.40	-128,158,540.40
<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>523,127,158.64</b>	<b>1,028,720,718.37</b>	<b>858,888,176.16</b>	<b>2,410,736,053.17</b>

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,760,529,700.00	1,653,276,366.11
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,760,529,700.00	1,653,276,366.11
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,699,544,500.00	1,593,487,666.11

<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,363,406,500.00	1,288,089,257.00
210101	Үндсэн цалин	842,496,800.00	750,432,967.00
210102	Нэмэгдэл	496,709,600.00	458,048,981.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	37,002,104.00
210104	Урамшуулал	24,200,100.00	42,605,205.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	170,542,100.00	161,947,527.68
210201	Тэтгэврийн даатгал	115,968,600.00	109,872,763.25
210202	Тэтгэмжийн даатгал	13,643,400.00	12,938,769.13
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,821,700.00	7,108,160.94
210204	Ажилгүйдлийн даатгал	6,821,700.00	6,391,425.16
210205	Эрүүл мэндийн даатгал	27,286,700.00	25,636,409.20
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	84,665,400.00	64,819,532.10
210502	Хоол, хүнс	84,665,400.00	64,819,532.10
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	21,403,300.00	20,938,539.33
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,368,400.00	2,368,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	19,034,900.00	18,570,139.33
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	59527200.00	57692810.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	52,740,600.00	50,921,710.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,786,600.00	6,771,100.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	60985200.00	59788700.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	60,985,200.00	59,788,700.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	60,985,200.00	59,788,700.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,760,529,700.00	1,629,496,300.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,658,056,400.00	1,625,987,900.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,658,056,400.00	1,625,987,900.00
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	102,473,300.00	3,508,400.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,368,400.00	2,368,400.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,785,000.00	1,140,000.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	98,319,900.00	
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	99,663,154.74
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	75,883,088.63
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	39	39
620001	Удирдах ажилтан	01	01
620002	Гүйцэтгэх ажилтан	27	27
620003	Үйлчлэх ажилтан	09	09
620004	Гэрээт ажилтан	02	02

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	137,779,600.00	137,779,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	137,779,600.00	137,779,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	137,779,600.00	137,779,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	137,779,600.00	137,779,600.00
210301	Гэрэл, цахилгаан	9,813,500.00	12,559,250.00
210302	Түлш, халаалт	120,494,300.00	120,264,350.00
210303	Цэвэр, бохир ус	4,771,800.00	2,256,000.00
210604	Урсгал засвар	2,700,000.00	27,000,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	137,779,600.00	137,779,600.00
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	137,779,600.00	137,779,600.00

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Завхан сумын Ерөнхий боловсролын сургууль нь “сурах арга барилтай, найрсаг харилцдаг, зөв дадалтай хүүхдийг төлөвшүүлэх” гэсэн зорилгыг дэвшүүлэн ажилласан байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Завхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Хөдөлмөр, Нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10-р сарын 07-ны өдрийн 03 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлс доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нэг цагт 4715 төгрөг буюу сард 792000 төгрөг байхаар шинэчлэн тогтоосон.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил

гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Завхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлсөн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Завхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн тайлант оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 133,526.0 мянган төгрөгөөр буюу 5.2 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	99,663.1	75,883.1	23,780.0
Авлага	0.0	691.3	691.3
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	106,964.5	115,228.1	8,263.6
Үндсэн хөрөнгө	2,339,763.6	2,221,062.9	-118,700.7
<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,546,391.3</b>	<b>2,412,865.3</b>	<b>-133,526.0</b>
Өр төлбөр	7,496.7	2,129.3	-5,367.4
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,538,894.6	2,410,736.1	-128,158.5
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>2,546,391.3</b>	<b>2,412,865.3</b>	<b>-133,526.0</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 115,228.1 мянган төгрөг болж 8,263.6 мянган төгрөгөөр өссөн нь бичиг хэрэг, аж ахуй, хоол хүнс, бусад хангамжийн материалын зарцуулалтаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 2,221,062.9 мянган төгрөг болж 118,700.7 мянган төгрөгөөр буурсан нь нь элэгдлийн зардлаас шалтгаалсан байна.

Авлагын үлдэгдэл 691.3 мянган төгрөг байгаа нь ажиллагсадтай холбоотой авлага байна. Үдийн хоолны зардлын зарцуулах эрх нээгдээгүйгээс 989.3 мянга, оны эцэст хийгдсэн гүйлгээ буцсанаас 1,140.0 мянга, нийт 2,129.3 мянган төгрөгийн өлөг үүссэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,410,736.1 мянган төгрөг болж 128,158.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурсантай холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,302,283.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг 354,462.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 1,656,745.8 мянган төгрөгөөр анх баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны анх батлагдсан төсвийг 103,783.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгол хийж төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,760,529.7 мянган төгрөгөөр баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,658,056.4 мянга, урд оны үлдэгдлээс 98,319.9 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 2,368.4 мянга, туслах үйл ажиллагааны орлогоос 1,785.0 мянга, нийт 1,760,529.7 мянган төгрөгийн санхүүжилт авч 1,653,276.4 мянган төгрөгийг зарцуулж 75,883.1 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэлтэй гарсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
№	Хөтөлбөр арга хэмжээ	төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	Биелэлт
1	Байр ашиглалтын үйлчилгээ	1,882,400.00	1,882,400.00	-	100%
2	Хүүхэд хамгаалал	1,935,600.00	1,814,000.00	121,600.00	94%
3	Сургалт семинар	1,105,100.00	1,105,100.00	-	100%
4	Эрүүл мэндийг дэмжих	2,060,500.00	2,011,210.00	49,290.00	98%
5	Үдийн цай хөтөлбөр	60,985,200.00	59,788,700.00	1,196,500.00	98%
6	Дотуур байр үйлчилгээ	354,313,600.00	291,497,465.87	62,816,134.13	82%
7	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	20,536,000.00	20,536,000.00	-	100%
8	Боловсролын байгууллагын багш ажилтны мэргэжил дээшлүүлэх	9,335,200.00	9,335,200.00	-	100%
9	Бичиг үсгийн боловсрол	8,737,000.00	6,373,971.25	2,363,028.75	73%
10	Боловсролын стандарт сургалт	1,269,279,100.00	1,239,218,079.66	30,061,020.34	98%
11	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	19,783,600.00	11,250,600.00	8,533,000.00	57%
12	Сурах бичиг түрээс	2,368,400.00	2,368,400.00	-	100%
13	сургалтын нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх	6,423,000.00	5,958,239.33	464,760.67	93%
14	Дээд шатны төсвөөс хуваарилсан	1,785,000.00	137,000.00	1,648,000.00	8%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Завхан сумын Засаг даргын тамгын газар нь орон нутгийн төсвөөс 137,779.6 мянган төгрөгийн санхүүжилт авч байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

Хүснэгт 3. Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн

/мянган төгрөг/			
№	Үзүүлэлт	Гүйцэтгэл	Тайлбар
1	Программ хангамжтай холбоотой гарсан зардал	0.0	байхгүй
2	Унаа хоолны зардлын гүйцэтгэл	37,000.0	Хоолны мөнгө өдрийн 5.0 мянган төгрөгөөр тооцдог.
3	Сургалт семинар, хурал зөвлөгөөнд зарцуулсан зардал	14,670.4	Багш нарын бага хурал бусад сургалт семинарын тээврийн зардал зарцуулсан
4	Гадаад томилолт, арга хэмжээнд зарцуулсан зардал	0.0	байхгүй
5	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой гарсан зардал	0.0	байхгүй
6	Байгууллагын орон тоо	42	Батлагдсан орон тоогоор ажилласан.
7	Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээ, төлбөрийн мэдээлэл	0.0	байхгүй

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Завхан сумын ерөнхий боловсролын сургууль тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Завхан сумын ерөнхий боловсролын сургууль нь тайлант онд 8,849.9 мянган төгрөгийн техник хэрэгсэл худалдан авсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Завхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Авирмэд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Завхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Өндөр” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,504,795.1 мянган төгрөгийн 0.5 хувиар буюу 7,523.9 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 6,019.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,942,318.8 мянган төгрөгийн 0.5 хувиар буюу 9,711.6 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 7.769.3 мянган төгрөгөөр тогтоосон.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Завхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй болно.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Завхан сумын Ерөнхий боловсролын сургууль нь цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 1,761,208.8 мянган төгрөгийн орлогын 17 гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 60,084.3 мянган төгрөгийн зарлагын 6 гүйлгээ, төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын 4 мэдээллийг шилэн дансны цахим хуудаст байршуулаагүй зөрчилд зөвлөмж өглөө.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Завхан сумын Ерөнхий боловсролын сургууль нь захирлын 2025 оны Б/47, Б/53 дугаар тушаалуудаар батлагдсан бүтэц, орон тоонд байхгүй статистик үнэлгээ хариуцсан сургалтын менежер, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан

ажилтан гэсэн 2 орон тоог хавсруулан гүйцэтгүүлж 4,910.8 мянган төгрөгийн нэмэгдэл олгосон нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтад “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулна”, 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалтад “Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох”, Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэгт “Төрийн албан хаагч хуульд зааснаас гадна дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно”, 39.1.2 дахь заалтад “албаны эрх мэдлээ хэтрүүлэх”, Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан зардлын эдийн засгийн ангиллыг зөрчиж 2,658.3 мянган төгрөгийн 11 гүйлгээ, анхан шатны бүрдэл дутуу баримтаар 3,418.0 мянган төгрөгийн 4 гүйлгээ, хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтад “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй тул холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Завхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 төлбөрийн акт тогтоосныг хэрэгжүүлэн ажилласан байна.

##### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

#### **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 3,591,971.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд 3 зөвлөмж өглөө.

##### **5.1 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### **1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

###### **1.1. Илрүүлэлт:**

Сургуулийн захирлын 2025 оны Б/47, Б/53 дугаар тушаалуудаар батлагдсан бүтэц, орон тоонд байхгүй статистик үнэлгээ хариуцсан сургалтын менежер, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан гэсэн 2 орон тоог хавсруулан гүйцэтгүүлж 4,910.8 мянган төгрөгийн нэмэгдэл олгосон байна.

###### **1.2. Өгсөн зөвлөмж:**

Цаашид Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалтад “Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох” гэж заасныг гэж заасныг мөрдөж ажиллах.

##### **2. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

###### **2.1. Илрүүлэлт:**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтад “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажууагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэж заасныг зөрчиж анхан шатны бүрдэл дутуу баримтаар 3,418.0 мянган төгрөгийн 4 гүйлгээ, Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан зардлын эдийн засгийн ангиллыг зөрчиж 2,658.3 мянган төгрөгийн 11 гүйлгээ хийсэн байна.

**2.2. Өгсөн зөвлөмж:**

Цаашид анхан шатны бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийхгүй байх, зардлын эдийн засгийн ангиллыг мөрдөж ажиллах.

**3. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

**3.1. Илрүүлэлт:**

Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 1,761,208.8 мянган төгрөгийн орлогын 17 гүйлгээ, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 60,084.3 мянган төгрөгийн зарлагын 6 гүйлгээ, 1,759,690.8 мянган төгрөгийн төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгааныг шилэн дансны цахим хуудаст байршуулаагүй байна.

**3.2. Өгсөн зөвлөмж:**

Цаашид Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмыг хэрэгжүүлэн ажиллах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 05-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хууль, тогтоомж зөрчсөн	2	10,987.1					2	10,987.1				
Дүн	2	10,987.1					2	10,987.1				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Мэдээлэл байршуулаагүй	1	3,580,983.9					1	3,580,983.9
Дүн	1	3,580,983.9					1	3,580,983.9
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Хууль, тогтоомж зөрчсөн								
Дүн								
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>3,580,983.9</b>					<b>1</b>	<b>3,580,983.9</b>

АУДИТЫН ТАЙЛАН

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР



/М.БАТСУУРЬ/

/М.БАТ-АМГАЛАН/

/Б.АВИРМЭД/

2026 оны 02 дугаар сарын 24-ний өдөр